

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	2-3
2	Аудитын тайлан .....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11	Шилэн дансны мэдээлэл .....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	11
3.1	Орлогын талаар .....	11
3.1.1	Илрүүлэлт:.....	11
3.1.2	Эрсдэл: .....	11
3.1.3	Өгсөн зөвлөмж: .....	11
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу тайлбар: .....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	12-13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	14-15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	16-17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	19
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	20
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

МАЛ АЖ АХУЙН ЭРДЭМ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН  
ЗАХИРАЛ Т.БАТСҮХ ТАНАА

2019.02.25 № 06/227  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2 Аудитын тайлан

### 2.1 Оршил

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус хүрээлэнгийн захирал Т.Батсүх Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, төсөв төлөвлөгөөтэй холбоотой зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 18-наас 2019 оны 2 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 21-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Нью Эстимэйтор Аудит ХХК-ийн аудитор Ж.Үхэртар хариуцаж хэрэгжүүлэв.

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн нь 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн №33 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн нь мал амьтан, бэлчээр тэжээлийн чиглэлээр шинжлэх ухаан, үйлдвэрлэл, оюуны бизнесийн үйл ажиллагааг хослон эрхэлдэг үндэсний хэмжээний эрдмийн цогцолбор болж, мал аж ахуйн тогтвортой хөгжилд бодит хувь нэмэр оруулна гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол Улсын Засгийн газрын 1977 оны 31 дүгээр тогтоолоор Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүй, бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн мал аж ахуй, бэлчээр тэжээлийн чиглэлээр суурь болон хавсрага судалгаа явуулах
- Оюуны багтаамж өндөртэй инноваци бүтээгдэхүүн үйлдвэрлэх
- Ашиг шим арвинтай шинэ үүлдэр, хэвшлийн мал амьтан, бүтээмж сайтай ургамлын сорт бий болгох

- Төр засгаас дэвшүүлж буй мал аж ахуйг хөгжүүлэх бодлого, зорилтын шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах
- Судалгааны ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, инноваци бүтээгдэхүүн бий болгох

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газар нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй бөгөөд Шинжлэх ухаан технологийн сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acolous", нэгтгэсэн тайлангийн "Plastic" програм хангамж ашигладаг байна.

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтын нэгжгүй тул дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт орлогын 2* хувиар сонгов.

*Нийт орлогыг* материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэгтэй холбоотой юм.

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны орлого үр дүнгийн тайлангийн *нийт орлого* 1,534,461.8 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 30,689.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь эрсдэл багатай гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 17 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.



Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй  
асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгөх	1	37,197.7	
2	Албан шаардлага өгөх	1	123,750.0	
	Дүн	2	160,947.7	

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Тус хүрээлэнгийн харьяа Дорнод бүсийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас 2013 онд 110,000.0 мянган төгрөгийн 7 жилийн хугацаатай, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийг авсан. Тус зээлийг 2016-2019 оны 5 сар хүртэл жил бүр 27,500.0 төгрөгийг төлж дуусгах графиктай байсан ч 2018 оны жилийн эцсийн байдлаар төлөлт огт хийгдээгүй байна.

Энэ нь аудитын бодитой оршин байх ба тохиолдсон байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна. Мөн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Иргэний хуулийн 227 дугаар зүйлийн 227.1-д “Гэрээний нэг тал үүргээ зөрчсөн бол нөгөө тал нь гэрээнээс татгалзсантай холбогдон учирсан хохирлыг арилгуулахаар шаардах эрхтэй”, зээлийн 2013 оны 2013-03 тоот гэрээний 4.2.1-д заасан “тухайн орон нутагтаа жимс, жимсгэний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, жимсний суулгац үржүүлгийн плантаци байгуулах арга хэмжээнд зээлээр авсан санхүүжилтыг 2013 оны 11 дүгээр сарын 1-ний дотор зарцуулж байгуулсан байх ба цаашид аж ахуйгаа тодорхой төлөвлөгөөтэй ажиллуулна”, 6.3-т “гэрээнд заасан хугацаанд зээлээ төлөөгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.3 хувийн алданги зээлдүүлэгч талд төлнө” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зээлийг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх талаар албан шаардлага өгөх

## **2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх явцад дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц 2 асуудлыг тодорхойлов.

1. Салбар хүрээлэнгүүдийн орлогыг бодитойгоор төлөвлөсөн эсэх
2. Эрдэм шинжилгээний төслийн зарцуулалтыг нягтлах

## **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 2018 онд 9 хөтөлбөр, арга хэмжээнд 1,411,838.2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,365,866.9 мянган төгрөг буюу 96.7 хувьтай байгаа ба нийт дүнгээр төсвийн зардлыг 3.3 хувиар буюу 45,971.2 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Энэ нь цалингийн зардалтай холбоотойгоор бий болсон бөгөөд тус байгууллагад 2018 онд нийт 10 амаржсан эх байгаагийн 4 нь докторын зэрэгтэй, 5 нь эрдэм шинжилгээний дэд ажилчид бөгөөд амаржсан эхчүүдийн оронд түр орлон ажиллаж буй мэргэжилтнүүд нь туслах эсвэл эрдэм шинжилгээний дадлагажигч ажилчид учраас зэрэг, цолны нэмэгдлийн зөрүүнээс дээрх хэмнэлт үүссэн байна. Мөн төсвийн зардал бүлэг хооронд хэтрээгүй боловч зардлыг бүлэг дотор гүйлгэн зарцуулсан байна. Тухайлбал, гэрэл цахилгааны зардлаас цэвэр бохир усны зардалд 6.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн нь төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 63.2 хувь буюу 37,197.7 мянган төгрөгөөр тасалдуулсан байна. Энэ нь тус хүрээлэнгийн төсвийн төсөлд санал оруулсан 32,614.4 мянган төгрөгийн саналыг үл харгалзан 26,284.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталснаас, мөн салбар хүрээлэнгүүдийн орлогыг бодитой төлөвлөөгүйгээс шалтгаалсан байна.

## **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тус хүрээлэн нь <http://shilendans.gov.mn> хаягаар тайлан мэдээг цаг хугацаанд нь оруулсан байна. Үүнд: батлагдсан төсөв гүйцэтгэлтэй холбоотой 12, төсвийн нэмэлт өөрчлөлттэй холбоотой 12, таван сая төгрөгөөс дээш үнэтэй худалдан авалттай холбоотой 8 мэдээ багтсан байна.

## **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөнөөс 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах талаар өгсөн зөвлөмж нь тус байгууллагын 2018 оны орон тоонд дотоод хяналтын ажилтны орон тоо батлагдаагүйтэй холбоотойгоор хэрэгжээгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг аудитын гүйцэтгэлийн шатанд дахин нягталсан болно.

## **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Орлогын талаар**

##### 3.1.1 Илрүүлэлт:

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн нь 2018 онд өөрийн үйл ажиллагаанаас 58,898.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс гүйцэтгэлээр 36.8 хувь буюу 21,701.1 мянган төгрөгийг төвлөрүүлж, төсвийн орлогыг 63.2 хувиар буюу 37,197.7 мянган төгрөгөөр тасалдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.4-т “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

##### 3.1.2 Эрсдэл:

Төсвийн орлого буурах, төсвийн алдагдал нэмэгдэх, үйл ажиллагаа үр ашиггүй болох

##### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, орлогыг бодитой төлөвлөх

##### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Аудитын өгсөн зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 7 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

#### 4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

##### 4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>822 215 133,37</b>	<b>982 244 590,72</b>
2	<b>АВЛАГА</b>	<b>41 615 057,39</b>	<b>45 479 818,24</b>
3	Бусад авлага	41 615 057,39	45 479 818,24
4	Байгууллагаас авах авлага	9 153 813,63	21 201 500,48
5	Хувь хүмүүсээс авах авлага	32 461 243,76	24 278 317,76
6	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>243 867 300,00</b>	<b>469 737 300,00</b>
7	Урьдчилж гарсан зардал	243 867 300,00	469 737 300,00
8	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>536 732 775,98</b>	<b>467 027 472,48</b>
9	<b>Түүхий эд материал</b>	<b>2 948 777,00</b>	-
10	Эм боох материал	2 948 777,00	-
11	Бэлэн бүтээгдэхүүн	13 502 024,56	14 443 524,56
12	<b>Хангамжийн материал</b>	<b>176 176 974,42</b>	<b>149 119 947,92</b>
13	Бичиг хэрэг	849 600,00	61 750,00
14	Аж ахуйн материал	5 089 649,00	3 656 351,00
15	Түлш, шатах тослох материал	0,74	722,24
16	Барилгын засварын материал	39 745 900,00	35 565 900,00
17	Хүнсний материал	5 877 300,00	2 145 500,00
18	Бусад хангамжийн материал	124 614 524,68	107 689 724,68
19	Мал амьтад	344 105 000,00	303 464 000,00
20	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1 138 636 656,28</b>	<b>8 603 158 341,48</b>
21	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1 138 636 656,28</b>	<b>8 603 158 341,48</b>
22	<b>Биет хөрөнгө</b>	<b>1 138 636 656,28</b>	<b>3 138 829 579,93</b>
23	Барилга байгууламж	1 360 618 587,00	2 670 634 202,85
24	Хуримтлагдсан элэгдэл	-789 455 734,92	-4 355 749,99
25	Авто тээврийн хэрэгсэл	474 695 503,08	474 695 503,08
26	Хуримтлагдсан элэгдэл	-307 023 936,42	-353 739 108,16
27	Машин, тоног төхөөрөмж	952 701 235,28	976 782 835,28
28	Хуримтлагдсан элэгдэл	-691 665 569,74	-767 398 497,77
29	Тавилга, аж ахуйн эд хогшил	149 817 133,00	161 462 173,00
30	Хуримтлагдсан элэгдэл	-121 649 702,59	-130 353 459,36
31	Бусад үндсэн хөрөнгө	111 459 000,00	113 609 000,00
32	Хуримтлагдсан элэгдэл	-1 459 000,00	-2 705 419,00
33	Номын фонд	198 100,00	198 100,00
34	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>401 041,59</b>	<b>5 464 328 761,55</b>
35	Програм хангамж	2 655 000,00	2 655 000,00
36	Хасагдуулга	-2 253 958,41	-2 446 458,45
37	Бусад биет бус хөрөнгө	-	5 464 120 220,00
38	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1 960 851 789,65</b>	<b>9 585 402 932,20</b>
39	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>132 327 899,72</b>	<b>155 426 587,20</b>
40	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>22 327 899,72</b>	<b>39 594 987,20</b>
41	<b>Өглөг</b>	<b>22 327 899,72</b>	<b>39 594 987,20</b>
42	Ажиллагчидтай холбогдсон өглөг	15 335 275,52	12 169 275,52

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

43	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2 797 400,00	11 871 967,48
44	<b>Бусад өглөг</b>	<b>4 195 224,20</b>	<b>15 553 744,20</b>
48	Байгууллагад төлөх өглөг	4 195 224,20	15 553 744,20
46	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	110 000 000,00	115 831 600,00
47	<b>Урт хугацаат зээл</b>	110 000 000,00	115 831 600,00
48	Төслийн зээл	110 000 000,00	115 831 600,00
49	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1 828 523 889,93</b>	<b>9 429 976 345,00</b>
50	Засгийн газрын хувь оролцоо	<b>1 828 523 889,93</b>	<b>9 429 976 345,00</b>
51	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн	<b>1 910 315 763,43</b>	<b>7 374 435 983,43</b>
52	Өмч: -Төрийн өмч	<b>1 828 523 889,93</b>	<b>9 429 976 345,00</b>
53	Хуримтлагдсан үр дүн	<b>-265 452 231,03</b>	<b>-239 837 457,42</b>
54	Өмнөх үеийн үр дүн	-247 633 325,41	-265 452 231,03
55	Тайлант үеийн үр дүн	-17 818 905,62	25 614 773,61
56	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	183 660 357,53	2 295 377 818,99
57	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1 960 851 789,65</b>	<b>9 585 402 932,20</b>

## 4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1 541 389 181,00</b>	<b>1 528 396 848,83</b>
2	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>67 356 526,00</b>	<b>98 814 719,00</b>
3	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>67 356 526,00</b>	<b>98 814 719,00</b>
4	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>67 356 526,00</b>	<b>98 814 719,00</b>
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3 632 600,00	9 477 599,00
6	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16 688 006,00	24 238 170,00
7	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	47 035 920,00	65 098 950,00
8	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1 474 032 655,00</b>	<b>1 429 582 129,83</b>
9	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1 336 216 900,00</b>	<b>1 344 165 879,83</b>
10	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1 336 216 900,00	1 344 165 879,83
11	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>137 405 755,00</b>	<b>85 416 250,00</b>
12	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	72 024 600,00
13	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан	120 955 000,00	5 877 500,00
14	Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16 450 755,00	7 514 150,00
15	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>410 000,00</b>	<b>-</b>
16	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	410 000,00	-
17	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>1 559 184 086,70</b>	<b>1 471 106 756,01</b>
18	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1 559 184 086,70</b>	<b>1 471 106 756,01</b>
19	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1 518 509 210,57</b>	<b>1 471 040 170,01</b>
20	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>888 717 990,00</b>	<b>920 645 528,75</b>
21	Цалин	872 559 599,00	919 831 028,75
22	Гэрээт ажлын хөлс	16 158 391,00	814 500,00
23	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>107 726 830,05</b>	<b>117 296 674,23</b>
24	Тэтгэврийн даатгалын шимтгэл	68 553 437,31	100 114 765,62
25	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	7 834 678,55	4 370 920,72
26	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	9 793 348,18	3 496 736,58
27	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1 958 669,63	846 750,03
28	Эрүүл мэндийн даатгалын хураамж	19 586 696,38	8 467 501,28
29	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>108 855 131,00</b>	<b>109 708 102,00</b>
30	Гэрэл цахилгааны зардал	49 882 082,00	54 034 343,00
31	Түлш, халаалтын зардал	46 319 939,00	46 024 659,00
	Цэвэр, бохир усны зардал	3 903 110,00	9 649 100,00
32	Байрны түрээс	8 750 000,00	-
33	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20 088 689,24</b>	<b>45 175 178,71</b>
34	Бичиг хэргийн материал	785 150,00	2 145 450,00
35	Тээвэр, шатахууны зардал	12 219 633,76	6 939 119,23
36	Шуудан холбоо интернетийн төлбөр	6 101 708,48	4 909 452,38

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

37	Ном хэвлэлийн зардал	80 200,00	80 200,00
38	Хог хаягдал устгах, цэвэрлэх	650 000,00	490 000,00
39	Бага үнэтэй түргэн элэгдэл зүйлс	251 997,00	727 437,10
40	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	308 520,00
41	Бараа материал акталсны зардал	-	29 575 000,00
42	<b>Нормативт зардал</b>	<b>2 488 116,00</b>	<b>19 144 500,00</b>
43	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	838 116,00	16 594 500,00
44	Хоол хүнс	-	837 000,00
45	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 650 000,00	1 713 000,00
46	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>17 535 100,00</b>	<b>4 980 000,00</b>
47	Урсгал засвар	17 535 100,00	4 980 000,00
48	<b>Томилолт , зочны зардал</b>	<b>10 607 485,00</b>	<b>18 475 873,90</b>
49	Дотоод албан томилолт	10 607 485,00	18 341 073,90
50	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	134 800,00
51	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>7 647 806,01</b>	<b>40 397 297 ,37</b>
52	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	4 200 006,01	34 877 979,37
53	Аудит ,баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	2 500 000,00
54	Тээврийн хэрэгслийн татвар	320 000,00	326 994,00
55	Газрын төлбөр	3 127 800,00	2 594 716,00
56	Банк, санхүүгийн байгууллагын үйлчил хураамж	-	97 608,00
57	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>354 842 063,27</b>	<b>195 217 015,05</b>
58	Бараа үйлчилгээний бусад зардал	118 579 398,46	36 319 698,00
59	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	236 262 664,81	158 897 317,05
60	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>40 674 876,13</b>	<b>66 586,00</b>
61	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>31 200 000,00</b>	-
62	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	31 200 000,00	-
63	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>9 474 876,13</b>	<b>66 586,00</b>
64	Төвлөрүүлэх шилжүүлэг	9 474 876,13	66 586,00
65	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>-17 794 905,70</b>	<b>57 290 092,82</b>
66	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	<b>6 065 000,00</b>
67	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	6 065 000,00
68	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>23 999,92</b>	<b>37 740 319,21</b>
69	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	36 480 000,00
70	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	-	1 260 319,21
71	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)</b>	<b>-23 999,92</b>	<b>-31 675 319,21</b>
72	<b>НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)</b>	<b>-17 818 905,62</b>	<b>25 614 773,61</b>



### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1 638 183 709,00</b>	<b>1 452 929 224,83</b>
2	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>40 961 713,00</b>	<b>21 701 095,00</b>
3	Нийтлэг татварын бус орлого	40 961 713,00	21 701 095,00
4	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>40 961 713,00</b>	<b>21 701 095,00</b>
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3 632 600,00	6 911 699,00
6	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37 329 113,00	14 789 396,00
7	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1 597 221 996,00</b>	<b>1 431 228 129,83</b>
8	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1 336 216 900,00</b>	<b>1 344 165 879 ,83</b>
9	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1 336 216 900,00	1 344 165 879 ,83
10	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>245 560 846,00</b>	<b>87 062 250,00</b>
11	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	283 384,00	72 024 600,00
12	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан	120 955 000,00	5 877 500,00
13	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	124 322 462,00	9 160 150,00
14	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>410 000,00</b>	-
15	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	410 000,00	-
16	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>15 034 250,00</b>	-
17	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	15 034 250,00	
18	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>1 645 121 337,00</b>	<b>1 423 034 184,83</b>
19	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1 645 121 337,00</b>	<b>1 423 034 184,83</b>
17	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1 604 446 460,87</b>	<b>1 422 967 598,83</b>
18	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>898 824 990,00</b>	<b>921 196 561,19</b>
19	Цалин	792 372 248,00	864 469 929,00
20	Нэмэгдэл цалин	65 573 998,00	41 426 932,19
21	Унаа хоолны хөнгөлөлт	33 750 800,00	14 169 200,00
22	Гэрээт ажлын хөлс	7 127 944,00	1 130 500,00
23	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>109 139 008,39</b>	<b>118 562 711,64</b>
24	Тэтгэврийн даатгалын шимтгэл	69 452 096,25	118 043 778,64
25	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	7 937 382,43	100 904,00
26	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	9 921 728,04	129 733,00
27	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1 984 345,60	28 830,00
28	Эрүүл мэндийн даатгал	19 843 456,07	259 466,00
29	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>108 855 131,00</b>	<b>104 798 200,00</b>
30	Гэрэл цахилгааны зардал	49 882 082,00	49 429 706,00
31	Түлш, халаалтын зардал	46 319 939,00	47 132 259,00
32	Цэвэр, бохир усны зардал	3 903 110,00	8 236 235,00
	Байрны түрээс	8 750 000,00	
33	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17 208 332,48</b>	<b>13 418 040,00</b>
34	Бичиг хэргийн материал	863 795,00	1 216 900,00
35	Тээвэр, шатахууны зардал	9 020 634,00	6 579 020,00

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

36	Шуудан холбоо интернетийн төлбөр	6 101 708,48	3 975 862,90
37	Ном хэвлэлийн зардал	200 200,00	120 300,00
38	Хог хаягдал устгах, цэвэрлэх	650 000,00	490 000,00
39	Бага үнэтэй түргэн элэгдэл зүйлс	371 995,00	1 035 957,10
40	<b>Нормативт зардал</b>	<b>2 488 116,00</b>	<b>1 650 000,00</b>
41	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	838 116,00	-
42	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 650 000,00	1 650 000,00
43	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10 199 700,00</b>	<b>863 000,00</b>
44	Багаж техник хэрэгсэл	3 000 000,00	-
45	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	63 000,00
46	Урсгал засвар	7 199 700,00	800 000,00
47	<b>Томилолт , зочны зардал</b>	<b>33 696 375,00</b>	<b>22 776 394,00</b>
48	Дотоод албан томилолт	33 696 375,00	22 776 394,00
49	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>303 981 611,00</b>	<b>239 702 692,00</b>
50	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	301 076 311,00	234 834 950,00
51	Аудит ,баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	2 500 000,00
52	Тээврийн хэрэгслийн татвар	320 000,00	326 994,00
53	Газрын төлбөр	2 585 300,00	1 943 140,00
54	Банк, санхүүгийн байгууллагын үйлчил хураамж	-	97 608,00
55	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>120 053 197,00</b>	-
56	Бараа үйлчилгээний бусад зардал	120 053 197,00	-
57	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>40 674 876,13</b>	<b>66 586,00</b>
58	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>31 200 000,00</b>	-
59	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	31 200 000,00	-
60	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>9 474 876,13</b>	-
61	Төвлөрүүлэх шилжүүлэг	9 474 876,13	66 586,00
62	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-6 937 628,00</b>	<b>29 895 040,00</b>
63	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	<b>-29 895 040,00</b>
64	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	-	<b>29 895 040,00</b>
65	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>29 895 040,00</b>
66	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	<b>29 895 040,00</b>
67	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		29 895 040,00
68	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
69	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
70	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

#### 4.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2017 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл</b>	<b>1 910 315 763,43</b>	<b>183 660 357,53</b>	<b>-247 635 325,41</b>	<b>1 846 342 795,55</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн			-17 818 905,62	-17 818 905,62
<b>2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>1 910 315 763,43</b>	<b>183 660 357,53</b>	<b>-265 452 231,03</b>	<b>1 828 523 889,93</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	5 464 120 220,00	2 111 717 461,46	-	7 575 837 681,46
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	25 614 773,61	25 614 773,61
<b>2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>7 374 435 983,43</b>	<b>2 295 377 818,99</b>	<b>-239 837 457,42</b>	<b>9 429 976 345,00</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр /

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1 411 838 200,00</b>	<b>1 365 866 974,83</b>	<b>45 971 225,17</b>	<b>96,7</b>
<b>IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1 411 838 200,00</b>	<b>1 365 866 974,83</b>	<b>45 971 225,17</b>	<b>96,7</b>
<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>1 411 838 200,00</b>	<b>1 365 866 974,83</b>	<b>45 971 225,17</b>	<b>96,7</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	<b>944 924 400,00</b>	<b>900 350 701,19</b>	<b>44 573 698,81</b>	<b>95,3</b>
Үндсэн цалин	822 519 200,00	846 866 929,00	-24 347 729,00	103,0
Нэмэгдэл цалин	73 974 000,00	39 314 572,19	34 659 427,81	53,1
Унаа, болон бусад нөхөн олговор	42 507 200,00	14 169 200,00	28 338 000,00	33,3
Урамшуулал	5 924 000,00	-	5 924 000,00	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	<b>113 391 100,00</b>	<b>112 381 439,64</b>	<b>1 009 660,36</b>	<b>99,1</b>
Тэтгэврийн даатгал	75 830 900,00	112 381 439,64	-36 550 539,64	148,2
Тэтгэмжийн даатгал	9 390 100,00		9 390 100,00	-
ҮОМШӨ-ний даатгал	7 512 000,00		7 512 000,00	-
Ажилгүйдлийн даатгал	1 878 100,00		1 878 100,00	-
Эрүүл мэндийн даатгал	18 780 000,00		18 780 000,00	-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	<b>102 952 400,00</b>	<b>102 952 400,00</b>	-	<b>100,0</b>
Гэрэл цахилгаан	54 580 400,00	48 979 706,00	5 600 694,00	89,7
Түлш, халаалт	46 332 000,00	45 736 459,00	595 541,00	98,7
Цэвэр, бохир ус	2 040 000,00	8 236 235,00	-6 196 235,00	403,7
Хангамж, бараа материалын зардал	<b>9 410 300,00</b>	<b>9 410 300,00</b>	-	<b>100,0</b>
Бичиг хэрэг	500 000,00	1 016 900,00	-516 900,00	203,4
Тээвэр (шатахуун)	3 000 000,00	3 079 800,00	-79 800,00	102,7
Шуудан холбоо, интернетийн төлбөр	5 510 300,00	3 975 862,90	1 534 437,10	72,2
Ном хэвлэл	100 000,00	120 300,00	-20 300,00	120,3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150 000,00	490 000,00	-340 000,00	326,7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	150 000,00	727 437,10	-577 437,10	485,0
Нормативт зардал	<b>1 650 000,00</b>	<b>1 650 000,00</b>	-	<b>100,0</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 650 000,00	1 650 000,00	-	100,0
Томилолт, зочны зардал	<b>5 500 000,00</b>	<b>5 500 000,00</b>	-	<b>100,0</b>
Дотоод албан томилолт	5 500 000,00	5 500 000,00	-	100,0
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>234 010 000,00</b>	<b>233 622 134,00</b>	<b>387 866,00</b>	<b>99,8</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	228 870 000,00	228 852 000,00	18 000,00	100,0
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2 500 000,00	2 500 000,00	-	100,0
Тээврийн хэрэгслийн татвар	654 000,00	326 994,00	327 006,00	50,0

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тээврийн хэрэгслийн оношилгоо	33 000,00	-	33 000,00	-
Газрын төлбөр	1 953 000,00	1 943 140,00	9 860,00	99,5
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1 411 838 200,00</b>	<b>1 365 866 974,83</b>	<b>45 971 225,17</b>	<b>96,7</b>
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1 352 939 400,00	1 344 165 879,83	8 773 520,17	99,4
Улсын төсвөөс санхүүжих	1 352 939 400,00	1 344 165 879,83	8 773 520,17	99,4
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	<b>58 898 800,00</b>	<b>21 701 095,00</b>	<b>37 197 705,00</b>	<b>36,8</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5 000 000,00	6 911 699,00	-1 911 699,00	138,2
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	53 898 800,00	14 789 396,00	39 109 404,00	27,4
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>105</b>	<b>105</b>	<b>-</b>	<b>100,0</b>
Удирдах ажилтан	1	1	-	100,0
Гүйцэтгэх ажилтан	82	82	-	100,0
Үйлчлэх ажилтан	22	22	-	100,0

## 5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.02.14	Аудитын нэр:	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн			САГ-2019/46/СТА-ТШЗ
				мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн харьяа Дорнод бүсийн сургалт эрдэм шинжилгээний хүрээлэн нь 2013 онд Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас “Зээл/2013-03” тоот зээлийн гэрээний дагуу 110,000,000.00 төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийг авсан. Тус зээлийг 2016-2019 онуудад жил бүр 27,500,000.00 төгрөг төлөхөөр хуваарьтай байсан хэдий ч эргэн төлөлтүүд хийгдээгүй байна.	123 750,0	Албан шаардлага өгөх	Захирал	Т.Батсүх
2	Өөрийн үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 36.8 хувьтай гүйцэтгэж, 63.2 хувь буюу 37,197.7 мянган төгрөгөөр тасалдуулсан байна.	37 197,7	Зөвлөмж өгөх	Захирал	Т.Батсүх
	<b>Дүн</b>	<b>160 947,7</b>			



## ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines provided for writing the summary.